

**ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН
ТАЙЛАН,ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	4
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	4
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	4
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	4
3. Аудитын тайлан.....	14
3.1. Ерөнхий зүйл.....	14
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	14
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	15
3.4. Материаллаг байдал	15
3.5. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлтүүд	16
3.5.1 Мөнгөн хөрөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө.....	6
3.5.2 Авлага.....	8
3.5.3 Урьдчилгаа.....	9
3.5.4 Бараа материал.....	10
3.5.5 Үндсэн хөрөнгө.....	11
3.5.6 Өр төлбөр.....	12
3.5.7 Засгийн газрын хувь оролцоо.....	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	20
3.7. Шилэн дансны нэгдсэн мэдээлэл	21
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	21
3.9. Аудитын илрүүлэлт.....	22
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	23
4. Менежментийн захидал	25
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	26

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ОБГ	Онцгой байдлын газар
ОБХ	Онцгой байдлын хэлтэс



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА, БРИГАДЫН
ГЕНЕРАЛ Г.АРИУНБУЯН ТАНАА

2021.03.25 № 01/1007
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Онцгой байдлын ерөнхий газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Онцгой байдлын ерөнхий газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Тус Онцгой байдлын ерөнхий газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшигтай тэмцэх, эрэн хайх, аврах, хор уршгийг хамгаалах, иргэнд чиглэсэн үйлчилгээ үзүүлэх зорилтот ажлын гүйцэтгэл 95.0 хувьтай байна.

Аудитын гол асуудал

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 2,998.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн "Тохиолдсон байх", "Үнэлгээ", "Эрх ба үүрэг", "Үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн нэгтгэсэн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ОРЛОГЧИЙН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	138,205,297.7	135,614,430.8
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	363,705.0	2,109,957.7
33	АВЛАГА	11,290,589.7	17,783,700.8
34	УРЬДЧИЛГАА	230,030.5	1,301,369.2
35	БАРАА МАТЕРИАЛ	52,159,706.2	43,922,266.2
36	НӨӨЦИЙН БАРАА	74,161,266.4	70,497,136.9
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	170,317,825.9	204,689,348.8
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	170,317,825.9	204,689,348.8
39100	Газар	0.0	0.0
39200	Биет хөрөнгө	140,629,912.4	175,162,797.0
39300	Биет бус хөрөнгө	29,687,913.5	29,526,551.8
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	308,523,123.7	340,303,779.6
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,072,721.8	2,975,432.5
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,072,721.8	2,975,432.5
41200	Богино хугацаат зээлийн өглөг	0.0	183,814.4
41300	Өглөг	1,014,177.8	2,176,001.1
41400	Урьдчилж орсон орлого	58,544.0	615,617.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	307,450,401.8	337,328,347.1
51	Засгийн газрын хувь оролцоо	307,450,401.8	337,328,347.1
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	90,719,170.0	90,485,170.0
51200	Хуримтлагдсан үр дүн	164,825,277.8	196,842,301.1
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	51,905,954.0	50,000,876.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	308,523,123.7	340,303,779.6

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	187,241,360.7	201,380,168.9
11	ТАТВАРЫН ОРЛОГО	0.0	0.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	74,516,752.0	63,292,192.7
120	Нийтлэг татварын бус орлого	74,516,752.0	63,292,192.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	112,724,608.6	138,087,976.2
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	133,837,173.0	163,763,224.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	133,837,173.0	163,763,224.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	126,960,368.0	152,821,488.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	54,910,935.7	63,022,177.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,609,210.9	1,886,797.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,945,979.3	4,349,417.2
2104	Хангамж, бараа материалын зардал	4,822,481.6	5,050,734.5
2105	Норматив зардал	5,959,678.0	5,802,817.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,246,719.3	15,620,389.3
2107	Томилолт, зочны зардал	2,333,530.5	1,579,798.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,603,491.9	9,045,374.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,528,340.6	46,463,983.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,876,805.0	10,941,735.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	0.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	53,404,187.7	37,616,944.9
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	3,110.0	145,400.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	13,753,964.2	2,027,993.7
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	39,653,333.4	35,734,351.2

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	119,694,072.6	170,587,536.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО	0.0	0.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,302,558.6	32,376,759.5
120	Нийтлэг татварын бус орлого	6,302,558.6	32,376,759.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	113,391,514.0	138,210,776.9
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	109,489,803.3	155,524,999.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	109,489,803.3	155,524,999.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	97,528,632.0	142,723,885.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	54,750,266.4	62,651,495.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,604,495.4	1,929,567.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,921,029.5	4,373,850.1
2104	Хангамж, бараа материалын зардал	2,778,251.3	3,666,460.5
2105	Нормативт зардал	4,570,132.3	7,412,222.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,104,221.9	6,091,942.4
2107	Томилолт, зочны зардал	1,882,321.0	1,463,048.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,710,784.2	10,138,252.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,207,130.0	44,997,046.2
211	ХҮҮ	0.0	0.0
212	ТАТААС	0.0	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,961,171.2	12,801,114.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	10,204,269.3	15,062,537.0
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	0.0	0.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	10,084,597.7	13,316,284.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,084,597.7	13,316,284.2
2200	Дотоод эх үүсвэрээр	10,084,597.7	13,316,284.2
2260	Гадаад эх үүсвэрээр	0.0	0.0

VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-10,084,597.7	-13,316,284.2
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	119,671.6	1,746,252.8
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	244,033.3	363,705.0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	363,705.0	2,109,957.7

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	264,262,880.4	264,262,880.4
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	3,550,851.9	3,550,851.9
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	267,813,732.2	267,813,732.2
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-16,663.8	-16,663.8
9	Тайлант үеийн үр дүн	39,653,333.4	39,653,333.4
11	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	307,450,401.8	307,450,401.8
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-3,717,327.9	-3,717,327.9
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	303,733,073.9	303,733,073.9
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-1,905,078.0	-1,905,078.0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-234,000.0	-234,000.0
19	Тайлант үеийн үр дүн	35,734,351.2	35,734,351.2
20	2020 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	337,328,347.1	337,328,347.1

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	117,696,372,400.00	116,937,653,124.54	758,719,275.46	99.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	106,414,330,200.00	105,656,612,773.54	757,717,426.46	99.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	98,357,296,000.00	97,600,793,172.54	756,502,827.46	99.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	62,647,263,300.00	62,262,033,372.40	385,229,927.60	99.4
210101	Үндсэн цалин	39,788,553,600.00	39,252,504,812.57	536,048,787.43	98.7
210102	Нэмэгдэл	21,327,125,900.00	21,408,855,242.66	-81,729,342.66	100.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,531,583,800.00	1,600,673,317.17	-69,089,517.17	104.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,011,861,400.00	1,888,831,953.22	123,029,446.78	93.9
210201	Тэтгэврийн даатгал	580,979,700.00	537,091,300.06	43,888,399.94	92.4
210202	Тэтгэмжийн даатгал	61,156,000.00	55,836,276.36	5,319,723.64	91.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	48,924,600.00	44,185,200.91	4,739,399.09	90.3
210204	Ажилгүйдлийн даатгал	12,231,100.00	13,369,129.81	-1,138,029.81	109.3
210205	Эрүүл мэндийн даатгал	1,308,570,000.00	1,238,350,046.08	70,219,953.92	94.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,287,009,800.00	4,125,395,547.97	161,614,252.03	96.2
210301	Гэрэл, цахилгаан	866,996,100.00	851,490,590.21	15,505,509.79	98.2
210302	Түлш, халаалт	2,891,234,100.00	2,786,035,758.46	105,198,341.54	96.4
210303	Цэвэр, бохир ус	246,752,100.00	206,603,058.56	40,149,041.44	83.7
210304	Байрны түрээс	282,027,500.00	281,266,140.74	761,359.26	99.7
2104	Хангамж, бараа материалын зардал	2,689,971,000.00	2,682,092,838.74	7,878,161.26	99.7
210401	Бичиг хэрэг	106,238,500.00	106,144,549.00	93,951.00	99.9
210402	Тээвэр, шатахуун	2,234,437,300.00	2,234,188,592.35	248,707.65	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	180,393,500.00	174,732,331.39	5,661,168.61	96.9
210404	Ном, хэвлэл	3,466,800.00	3,466,800.00	0.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	22,970,700.00	21,664,466.00	1,306,234.00	94.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	142,464,200.00	141,896,100.00	568,100.00	99.6
2105	Норматив зардал	6,606,811,900.00	6,591,562,909.20	15,248,990.80	99.8
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,292,651,400.00	1,291,790,575.40	860,824.60	99.9
210502	Хоол, хүнс	2,352,718,900.00	2,338,349,816.80	14,369,083.20	99.4
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,961,441,600.00	2,961,422,517.00	19,083.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,400,590,200.00	7,394,669,571.64	5,920,628.36	99.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,162,082,600.00	4,159,892,026.00	2,190,574.00	99.9
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	285,020,500.00	284,622,619.64	397,880.36	99.9
210604	Урсгал засвар	2,953,487,100.00	2,950,154,926.00	3,332,174.00	99.9
2107	Томилолт, зочны зардал	85,700,200.00	78,532,080.00	7,168,120.00	91.6
210702	Дотоод албан томилолт	85,630,200.00	78,462,080.00	7,168,120.00	91.6
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	70,000.00	70,000.00	0.00	100.0

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,965,220,400.00	11,924,537,378.67	40,683,021.33	99.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,744,800,300.00	10,743,871,852.19	928,447.81	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	31,645,500.00	28,421,248.00	3,224,252.00	89.8
210803	Даатгалын үйлчилгээ	896,697,900.00	896,572,976.36	124,923.64	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	93,105,900.00	75,908,210.00	17,197,690.00	81.5
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	23,807,700.00	21,742,634.00	2,065,066.00	91.3
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	36,612,900.00	36,132,340.00	480,560.00	98.7
210807	Газрын төлбөр	138,383,500.00	121,780,818.12	16,602,681.88	88.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	166,700.00	107,300.00	59,400.00	64.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	662,867,800.00	653,137,520.70	9,730,279.30	98.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	264,122,600.00	257,280,519.00	6,842,081.00	97.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	398,745,200.00	395,857,001.70	2,888,198.30	99.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,057,034,200.00	8,055,819,601.00	1,214,599.00	100.0
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	169,510,000.00	169,509,240.00	760.00	100.0
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	169,510,000.00	169,509,240.00	760.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,887,524,200.00	7,886,310,361.00	1,213,839.00	100.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	200,000,000.00	200,000,000.00	0.00	100.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	4,500,000.00	4,475,000.00	25,000.00	99.4
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,141,225,500.00	7,141,225,500.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	541,798,700.00	540,609,861.00	1,188,839.00	99.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,282,042,200.00	11,281,040,351.00	1,001,849.00	100.0
220001	Барилга байгууламж	3,802,300,000.00	3,802,299,921.00	79.00	100.0
222001	Тоног төхөөрөмж	50,000,000.00	49,891,000.00	109,000.00	99.8
224001	Стратегийн нөөц хөрөнгө	7,429,742,200.00	7,428,849,430.00	892,770.00	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	117,696,372,400.00	117,613,099,687.61	83,272,712.39	99.9
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	113,032,541,200.00	112,265,805,554.54	766,735,645.46	99.3
310001	Улсын төсвөөс санхүүжих	113,032,541,200.00	112,265,805,554.54	766,735,645.46	99.3
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4,663,831,200.00	5,347,294,133.07	-683,462,933.07	114.7
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,663,831,200.00	5,338,384,993.07	-674,553,793.07	114.5
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	8,909,140.00	-8,909,140.00	

6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	9,958	9,548	410	95.9
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	38	38	0	100.0
610001	Төсвийн байгууллага	38	38	0	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	4,960	4,755	205	95.9
620001	Удирдах ажилтан	39	39	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	4,351	4,151	200	95.4
620003	Үйлчлэх ажилтан	570	565	5	99.1
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	4,960	4,755	205	95.9
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	4,390	4,190	200	95.4
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	570	565	5	99.1

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

		/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	28,886,605,697.79
21	УРСГАЛ ЗАРДАЛ	28,617,697,859.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	25,179,135,158.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	20,736,740.00
210101	Үндсэн цалин	20,736,740.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	78,317,022.90
210301	Гэрэл, цахилгаан	9,487,464.90
210302	Түлш, халаалт	6,940,174.00
210303	Цэвэр, бохир ус	1,889,384.00
210304	Байрны түрээс	60,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	990,004,449.00
210401	Бичиг хэрэг	45,179,621.00
210402	Тээвэр, шатахуун	886,045,953.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,836,175.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	48,842,700.00
2105	Норматив зардал	996,717,099.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	478,701,913.00
210502	Хоол, хүнс	506,055,386.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	11,959,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	558,646,971.70
210601	Багаж, техник, хэрэгсэл	184,896,087.50
210602	Тавилга	52,200,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	44,534,391.00
210604	Урсгал засвар	277,016,493.20
2107	Томилолт, зочны зардал	1,221,626,573.00
210701	Гадаад албан томилолт	1,000,000.00
210702	Дотоод албан томилолт	1,217,041,273.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	3,585,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,770,731,250.36
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,767,381,250.36
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,350,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,542,355,052.58
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,525,798,484.58
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,556,568.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,438,562,701.25
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,672,577,803.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	32,410,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	43,116,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,597,051,303.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,765,984,898.25
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,765,984,898.25
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	268,907,838.00
2200	Дотоод эх үүсвэрээр	268,907,838.00

225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	268,907,838.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	28,886,605,697.79
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	28,886,605,697.79
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	7,444,915,986.46
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,017,616,946.81
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,120,670,055.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,303,402,709.52
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд Онцгой байдлын ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч, бригадын генерал Г.Ариунбуян танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээд Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, харилцагч байгууллагуудтай тооцоо нийлэх, олон жил болсон авлагуудыг барагдуулах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах, харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 05-наас 2021 оны 03 дугаар сарын 25-ны хооронд Үндэсний аудитын газрын ахлах аудитор Р.Цолмон, гэрээт аудитор М.Ганбаатар нар хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Онцгой байдлын ерөнхий газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1. Гамшгаас хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгож, бодлого зохицуулалтыг сайжруулах, үндэсний болон бүс нутаг, олон улсын хэмжээнд гамшгийн эрсдэлийг бууруулах түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлэх,
2. Гамшгийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлж бэхжүүлэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд шинжлэх ухаан, инновацыг нэвтрүүлэх,
3. Байгууллагын удирдлагын манлайлал, хүний нөөцийн хөгжлийг хангаж, чадавхыг бэхжүүлэх,
4. Гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүх нийтийн үйл хэрэг болгон, иргэд, олон нийтийн гамшгаас хамгаалах мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлж, гамшгийн эрсдэлийг бууруулахад олон нийтийн оролцоог хангах,
5. Гамшгаас хамгаалах мэргэжлийн удирдлага зохицуулалтыг сайжруулж, хүч хэрэгслийн бэлэн байдлыг дээшлүүлэх, гамшгийн голомтод эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох чадавхыг бэхжүүлэх,
6. Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, улсын хяналтыг хэрэгжүүлэх замаар галын аюулгүй байдлыг хангах, гал түймэртэй тэмцэх тогтолцоог бэхжүүлж, хүч хэрэгслийн бэлэн байдлыг сайжруулах,
7. Улсын нөөцийг удирдлага, зохицуулалтаар хангах, хүмүүнлэгийн тусламжийн зохицуулалтыг сайжруулж, гамшгийн дараах үйл ажиллагааг эрчимжүүлэх,
8. Төсөв санхүү, хангалт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх,
9. Гамшгаас хамгаалах хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитыг зохион байгуулж гамшгаас хамгаалах үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Коронавируст халдварын /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг 2020 оны 4 дүгээр сарын 29-нд батлуулав,
- УИХ-ын 2020 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн чуулганаар Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан,
- ОБЕГ-ын эд хөрөнгийн бүртгэлийн программыг нэвтрүүлж QR коджуулах ажлыг нэвтрүүлсэн,
- Тусгай үүргийн нислэг болон хилийн боомтуудаар татан авсан 22609 иргэдийг тусгаарлах байранд түр байршуулсан 26,093.7 сая төгрөгийн төлбөр тооцоог Хаан банкны үйлчилгээтэй холбон цахимжуулсан байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Онцгой байдлын ерөнхий газар санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Онцгой байдлын ерөнхий газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Санхүүгийн тооцоолох ХХК-ийн Acolous программ хангамж ашигладаг байна.

Дотоод хяналт шалгалт, аюулгүй байдлын газар нь 2020 онд төвлөрүүлэн захирагчийн харьяа 17 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, нийт 376.7 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 16 зөвлөмж өгсөн байна.

Дотоод аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэхэд 361.4 сая төгрөгийн зөвлөмжийг хэрэгжүүлж, 15.4 сая төгрөгийн зөвлөмж хэрэгжээгүй байна.

Дотоод хяналт шалгалт, аюулгүй байдлын газар 2020 оны шилэн дансанд хийсэн дотоод аудитаар харьяа салбар нэгжийн 4 байгууллагын шилэн дансны 13 мэдээллийг оруулсан байна.

Онцгой байдлын ерөнхий газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардлын дүнг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардлын 174,115.9 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 1,741.1 сая төгрөгөөр тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын дүн болох 163,763.2 сая төгрөгөөс 1.0 хувиар тооцон материаллаг байдлын түвшинг 1,637.6 сая төгрөгөөр тооцсон нь аудитын залруулга хийсэн суурь үзүүлэлтийн дүнг авч үзсэнтэй холбоотой байна.

3.5. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлтүүд

3.5.1 Мөнгөн хөрөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 363.7 сая, эцсийн үлдэгдэл 2,109.9 сая төгрөг болж, 1,746.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1 Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	0.2	0.1	-0.1
Банканд байгаа бэлэн мөнгө	363.5	2,109.8	1,746.3
Дүн	363.7	2,109.9	1,746.2
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	363.7	1,369.5	1,005.8
ТӨҮГ болон ОНӨҮГ		740.4	740.4
Дүн	363.7	2,109.9	1,746.2

Эх сурвалж: ОБЕГ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Банканд байршиж буй 2,109.9 сая төгрөгөөс 1,369.5 сая төгрөг нь төсөвт байгууллагын, 740.4 сая төгрөг нь улсын төсөвт үйлдвэрийн газрын үлдэгдэл байна.

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 1,746.2 сая төгрөгөөр өссөн нь “COVID-19” вирусээс урьдчилан сэргийлэх зорилгоор Шадар сайдын 2020 оны 23 дугаар тушаалын дагуу гадаад улс орнуудаас ирж байгаа иргэдийг түр тусгаарлах байранд байрлуулах ор хоногийн төлбөрийг Хаан банкны 5084538375 тоот дансанд төвлөрүүлсэн болон иргэд аж ахуйн нэгж байгууллагуудаас хандивласан мөнгөн хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Аудитын илрүүлэлт:

- Давтан сургалт, сургалт, сэргээн заслын төвийн нийт 1,304.5 сая төгрөгийн мөнгөн үйл ажиллагааны зарцуулалтад дээд шатны байгууллага хяналт тавиагүй,
- Анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн нийт 53.9 сая төгрөгийн зөрчил байна. /ОБЕГ аппарат 50.0 сая, Баянгол дүүргийн ОБХ 1.8 сая, Сүхбаатар дүүргийн ОБХ 2.1 сая төгрөг/;
- ОБЕГ-ын аппарат ЗГ-ын холбогдох шийдвэрийг зөрчин 503.8 сая төгрөгийн зориулалт бус зардлыг санхүүжүүлж, зардал гаргасан,
- Татварын цахим төлбөрийн баримтын системд И баримтгүй шилжүүлсэн болон зөрүүтэй тайлагнасан нийт 254.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн. /Давтан сургалт, сургалт сэргээн засал 67.0 сая, Нийслэлийн ОБГ 31.4 сая, Говь-Алтай аймгийн ОБГ 51.7 сая, Сүхбаатар дүүргийн ОБХ 42.5 сая, Баянгол дүүргийн ОБХ 8.6 сая, Баянзүрх дүүргийн ОБХ 5.4 сая, Багануур дүүргийн ОБХ 20.6 сая, Налайх дүүргийн ОБХ 4.0 сая, Сонгино хайрхан дүүргийн ОБХ 23.6 сая төгрөг/;
- Цалин, урамшууллын зардлыг илүү, дутуу тооцсон, түүнтэй холбоотой татварын зардлыг зөрүүтэй олгосон нийт 102.0 сая төгрөгийн зөрчил байна. /Булган аймгийн ОБГ 0.8 сая, Завхан аймгийн ОБГ 26.0 сая, Хэнтий аймгийн ОБГ 31.8 сая, Говь-Алтай аймгийн ОБГ 10.9 сая, Орхон аймгийн ОБГ 0.1 сая, Сэлэнгэ аймгийн ОБГ 2.2 сая, Өмнөговь аймгийн ОБГ 1.7 сая, Дорнод аймгийн ОБГ 1.4 сая, Сүхбаатар аймгийн ОБГ 2.9 сая, Багануур дүүргийн ОБХ 0.2 сая, Чингэлтэй дүүргийн ОБХ 24.0 сая төгрөг/.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 11,290.6 сая, эцсийн үлдэгдэл 17,783.7 сая төгрөг болж 6,493.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	17.8	16.2	-1.6
Төлбөртэй үйлчилгээний авлага	3.1	1.8	-1.3
Татаас, санхүүжилтийн авлага	45.1	2,086.8	2,041.7
Бусад авлага	11,224.6	15,678.9	4,454.3
Дүн	11,290.6	17,783.7	6,493.1
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	11,283.2	17,778.1	6,494.9
ТӨҮГ болон ОНӨҮГ	7.4	5.6	-1.8
Дүн	11,290.6	17,783.7	6,493.1

Эх сурвалж: ОБЕГ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд нийт авлага 6,493.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Улсын нөөц 4,526.0 сая төгрөгөөр, татаас санхүүжилтийн авлага 2,041.7 сая төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Авлагын дансны үлдэгдэлд он удаан жил болсон 3,272.0 сая төгрөгийн Улсын нөөцийн авлага байгаа нь нийт авлагын 18.4 хувь байна.

Аудитын илрүүлэлт:

- Авлагын үлдэгдэл 366.6 сая төгрөгийн тооцоог нийлж баталгаажуулаагүй. /ОБЕГ аппарат 365.5 сая, Хан-Уул дүүргийн ОБХ 1.1 сая төгрөг/;
- Олон жил болсон 11.1 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй. /Сэлэнгэ аймгийн ОБГ 10.4 сая, Завхан аймгийн ОБГ 0.7 сая төгрөг/;

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 230.0 сая, эцсийн үлдэгдэл 1,301.4 сая төгрөг болж, 1,071.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Урьдчилгаа дансны үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	230.0	1,301.4	1,071.4
Дүн	230.0	1,301.4	1,071.4
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	230.0	1,300.0	1,070.0
ТӨҮГ болон ОНӨҮГ		1.4	1.4
Дүн	230.0	1,301.4	1,071.4

Эх сурвалж: ОБЕГ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэлд 2020 онд үүссэн 1,301.4 сая төгрөгийн бараа ажил, үйлчилгээний төлбөрүүд байна. Тухайлбал:

- ОБЕГ-ын засварын зардалд 76.8 сая төгрөг,
- Автомашин /шуурхай алба/-ны урьдчилгаа төлбөрт 51.4 сая төгрөг,
- Тээврийн хэрэгсэл, жолоочийн хариуцлагын даатгалын зардалд 274.4 сая төгрөг,
- Гэнэтийн ослын даатгалд 69.5 сая төгрөг,
- Дүрэмт хувцасны үнэнд 614.5 сая төгрөг,
- Нөөцийн барааны даатгалд 34.8 сая төгрөг,
- Тэжээлийн урьдчилгаанд 144.6 сая төгрөг байна.

Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газар нь 2019 онд албан газрын байрны урьдчилгаанд 26.0 сая төгрөг шилжүүлсэн боловч үлдэгдэл санхүүжилтийг олгож чадахгүй байгаагаас үндсэн хөрөнгийн дансанд бүртгээгүй байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 52,159.7 сая, эцсийн үлдэгдэл 43,922.3 сая төгрөг болж, 8,237.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №4 Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	34,752.5	26,353.8	-8,398.7
Дуусаагүй үйлдвэрлэл	158.7	24.9	-133.8
Бэлэн бүтээгдэхүүн	1,305.3	2,214.7	909.4
Хангамжийн материал	15,836.6	15,166.8	-669.8
Биологийн хөрөнгө	65.0	110.2	45.2
Мал амьтад	41.6	51.9	10.3
Дүн	52,159.7	43,922.3	8,237.4
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	51,720.2	43,123.5	-8,596.7
ТӨҮГ болон ОНӨҮГ	439.5	798.8	359.3
Дүн	52,159.7	43,922.3	-8,237.4

Эх сурвалж: ОБЕГ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн бараа материал 35,348.4 сая, үнэ төлбөргүй хандиваар бэлтгэсэн 7,300.4 сая, балансаас балансад шилжүүлэн авсан 9,667.5 сая, бусад 553.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, худалдаж, зарцуулсан 36,345.1 сая, балансаас балансад шилжүүлсэн 26,711.0 сая, бусад 1,721.2 сая төгрөгөөр тус тус хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Бараа материалын дансанд үндсэн хөрөнгө бүртгэсэн нийт 69.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн. /Нийслэлийн ОБГ 13.7 сая, Сонгино хайрхан дүүргийн ОБХ 3.9 сая, Төв аймгийн ОБГ 51.6 сая төгрөг/;
- Бараа материалын дансанд хөрөнгийг эдийн засгийн ангиллыг буруу бүртгэсэн, нийт 19.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн. /Сүхбаатар аймгийн ОБГ 16.3 сая, Завхан аймгийн ОБГ 3.6 сая төгрөг/;
- Анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар бараа материалын зарлага гаргасан, шууд зардалд бүртгэсэн нийт 29.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн. /Завхан аймгийн ОБГ 13.6 сая, Говь-Алтай аймгийн ОБГ 0.4 сая, Дорнод аймгийн ОБГ 0.6 сая, Баянгол дүүргийн ОБХ 6.8 сая, Чингэлтэй дүүргийн ОБХ 8.4 сая төгрөг/;

3.5.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 170,317.8 сая, эцсийн үлдэгдэл 204,689.3 сая төгрөг болж, 34,371.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	140,629.9	175,162.8	34,532.9
Биет бус хөрөнгө	29,687.9	29,526.5	-161.4
Дүн	170,317.8	204,689.3	34,371.5
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	165,545.1	199,251.0	33,705.9
ТӨҮГ болон ОНӨҮГ	4,772.7	5,438.3	665.6
Дүн	170,317.8	204,689.3	34,371.5

Эх сурвалж: ОБЕГ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн үндсэн хөрөнгө 6,463.1 сая төгрөг, үнэ төлбөргүй хандиваар бэлтгэсэн 3,857.4 сая төгрөг, балансаас балансад шилжүүлэн авсан

45,257.8 сая, бусад 37,023.4 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, худалдсан болон акталсан 3,054.0 сая төгрөг, балансаас балансад шилжүүлсэн 47,445.6 сая, бусад 2,263.5 сая төгрөгөөр тус тус хасагдсан байна.

Дуусаагүй барилга дансанд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй 3,235.0 сая төгрөгийн Чингэлтэй дүүргийн Гал унтраах 10 дугаар ангийн барилга, Аврах гал унтраах ангийн барилга, 2018 оноос баригдаж буй Увс аймгийн Баруунтуруун сумын 567.3 сая төгрөгийн барилгууд байна.

Аудитын илрүүлэлт:

•Худалдан авах ажиллагааны хууль, журмыг зөрчсөн, зориулалт бус зардлаас хөрөнгө бэлтгэсэн нийт 81.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн. /Нийслэлийн ОБГ 34.1 сая, Чингэлтэй дүүргийн ОБХ 36.4 сая, Сонгино хайрхан дүүргийн ОБХ 11.0 сая төгрөг/;

•Жилийн эцсийн тооллогын дүн санхүүгийн тайланд бүртгэлтэй хөрөнгөөс зөрүүтэй, зарим хөрөнгө биетээр оршин байхгүй, зарим хөрөнгө өөр байгууллагын дансанд давхар бүртгэсэн, элэгдлээ нөхсөн үлдэх өртөггүй нийт 879.3 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна. /Архангай аймгийн ОБГ 831.4 сая, Сүхбаатар аймгийн ОБГ 9.3 сая, Хан-Уул дүүргийн ОБХ 38.6 сая төгрөг/;

•ОБЕГ-ын аппарат холбогдох газрын зөвшөөрөлгүй бэлтгэсэн Hyundai Sonata DNB /шуурхай алба/-ны автомашиныг 92.0 сая төгрөгөөр худалдан авсан байна.

3.5.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 1,072.7 сая, эцсийн үлдэгдэл 2,975.4 сая төгрөг болж, 1,902.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өссөн (+) Буурсан (-)
<i>Богино хугацаат өр төлбөр дүн</i>	1,072.7	2,975.4	1,902.7
Богино хугацаат зээлийн өглөг	0.0	183.8	183.8
Ажилчидтай холбогдсон өглөг	18.1	2.0	-16.1
Бараа үйлчилгээний зардлын өглөг	64.3	4.7	-59.6
Бусад өглөг	931.8	2,169.3	1,237.5
Урьдчилж орсон орлого	58.5	615.6	557.1
Дүн	1,072.7	2,975.4	1,902.7
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	972.9	2,351.9	1,379.0
ТӨҮГ болон ОНӨҮГ	99.8	623.5	523.7
Дүн	1,072.7	2,975.4	1,902.7

Эх сурвалж: ОБЕГ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 1,122.9 сая төгрөгийн иргэдийн төлсөн тусгаарлах байрны төлбөр, 710.2 сая төгрөгийн нөөцийн бараа, ажил үйлчилгээний төлбөр, 134.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын барьцаа, 1,007.6 сая төгрөгийн бусад бараа, ажил үйлчилгээний төлбөр байна.

Аудитын илрүүлэлт:

• Өглөгийн үлдэгдэл 202.1 сая төгрөгийн тооцоог нийлж баталгаажуулаагүй зөрчил илэрсэн байна. /ОБЕГ аппарат 201.4 сая, Хан-Уул дүүргийн ОБХ 0.7 сая төгрөг/;

3.5.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 307,450.4 сая, эцсийн үлдэгдэл 337,322.1 сая төгрөг болж, 29,871.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7 Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал				
/Засгийн газрын сан/ орон нутгийн сан	90,719.2	90,485.2	-234.0	26.8
Хуримтлагдсан үр дүн	164,825.3	196,836.1	32,010.8	58.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	51,905.9	50,000.8	-1,905.1	14.8
Дүн	307,450.4	337,322.1	29,871.7	100.0
Үүнээс, байгууллагын төрлөөр				
Төсөвт байгууллага	5,121.6	6,360.9	1,239.3	1.9
ТӨҮГ болон ОНӨҮГ	302,328.8	330,961.2	28,632.4	98.1
Дүн	307,450.4	337,322.1	29,871.7	100.0

Эх сурвалж: ОБЕГ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оруулсан капитал данс Хэнтий аймгийн ОБХ 249.0 сая төгрөгийн газрыг шилжүүлж, Багануур дүүргийн ОБХ 15.0 сая төгрөгийн газрыг санхүүгийн тайланд бүртгэсэн.

Хуримтлагдсан үр дүн данс нийт 3,717.3 сая төгрөгөөр хорогдсон нь Улсын нөөцийн газар 5,771.1 сая төгрөгөөр урьд онд зарцуулагдсан шатахууныг зарлагдсан, үлдэгдэл 2,053.8 сая төгрөг нь харьяа байгууллагуудын акталсан хөрөнгөөр нэмэгдсэн байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 249,472.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 131,775.7 сая төгрөгөөр бууруулж 117,696.4 сая төгрөгөөр баталсан нь өмнөх оны төсвөөс 16,923.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 8 дугаар сарын 331 дүгээр тогтоолоор Хөвсгөл аймгийн Галт суманд Гал унтраах, аврах анги, Сэлэнгэ аймгийн Хүдэр, Хэнтий аймгийн Баян-Адарга, Баянхонгор аймгийн Жаргалант суманд Эрэн хайх, аврах салбар, Өвөрхангай аймгийн Хужирт суманд Эрэн хайх аврах бүлгийг тус тус шинээр байгуулсантай холбоотой байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 14 арга хэмжээг санхүүжүүлэхээр 117,696.3 сая төгрөгийн төсөв баталснаас 113,032.5 сая төгрөгийг улсын төсвөөс 4,663.8 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 112,265.8 сая төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 5,347.3 сая төгрөг, нийт 117,613.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 105,656.6 сая төгрөг, хөрөнгийн зардалд 11,281.0 сая төгрөг зарцуулж, 675.5 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 116,937.6 сая төгрөг буюу 99.4 хувьтай байгаа нь 1 хөтөлбөрийн 14 арга хэмжээний бараа, ажил үйлчилгээний зардлыг 756.5 сая төгрөгөөр,

урсгал шилжүүлгийн зардлыг 1.2 сая төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 1.0 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 7,347.1 сая төгрөг, гадаад төсөл хөтөлбөрөөс 131.6 сая, Засгийн газрын нөөц сангаас 15,017.6 сая, дээд шатны төсвийн захирагчаас 3,120.7 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 3,401.2 сая, нийт 28,886.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бараа, ажил үйлчилгээний зардалд 25,179.1 сая, хөрөнгийн зардалд 268.9 сая, бусад урсгал шилжүүлгийн зардалд 1,672.6 сая төгрөг нийт 27,120.6 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 1,766.0 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

3.7. Шилэн дансны нэгдсэн мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 6557 мэдээллээс хугацаандаа оруулсан 5500 мэдээлэл, хугацаа болоогүй 69 мэдээлэл, хугацаа хоцроож мэдээлсэн 742 мэдээлэл, 246 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна. Үүнд:

- ОБЕГ-ын аппарат 6 мэдээллийг байршуулаагүй,
- Чингэлтэй дүүргийн ОБХ шилэн дансанд 36.4 сая төгрөгийн "Хашхан" ХХК-аас харьцуулалтын аргаар сонгон шалгаруулсан үндсэн хөрөнгө, худалдан авалтын мэдээллийг байршуулаагүй, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгааны мэдээллийг оруулаагүй,
- Сонгинохайрхан дүүргийн ОБХ 297.7 сая төгрөгийн орлогын гүйлгээг мэдээлээгүй,
- Завхан аймгийн ОБГ цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ, худалдан авалт, хандив тусламж, аудитын зөвлөмжийн хэрэгжилт зэрэг 661.8 сая төгрөгийн мэдээлэл,
- Хэнтий аймгийн ОБГ 135.2 сая төгрөгийн 2 гүйлгээ, зарлагын 388.0 сая төгрөгийн 12 гүйлгээг,
- Говь-Алтай аймгийн ОБГ 200.6 сая төгрөгийн орлого, зарлагын 18 гүйлгээг,
- Дорнод аймгийн ОБГ 6.0 сая төгрөгийн гүйлгээг тус тус мэдээлээгүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар өгсөн 836.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах 6 албан шаардлагыг биелүүлсэн байна. Аудитаар өгсөн 1,307.1 сая төгрөгийн 10 зөвлөмжийн хэрэгжилт 98.9 хувьтай байна.

Хүснэгт №8 Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	6	836.4	6	836.4	-	-	100.0
Зөвлөмж	10	1,307.1	9	1,307.1	1	0.0	98.9
Нийт дүн	16	2,143.5	15	2,143.5	1	0.0	93.7

Өмнөх оны аудитаар өгсөн 1 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэх талаар Үндэсний аудитын газрын 2021 оны 70/АО160059 дугаар албан шаардлагыг хүргүүлсэн.

3.9. Аудитын илрүүлэлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 40 төсвийн байгууллага, 1 улсын төсөвт үйлдвэрийн газар нийт 41 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 39 байгууллага аудитад хамрагдсан, 2 байгууллагад итгэл үзүүлсэн байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас 7 байгууллагыг түүвэрт хамруулж, 31 байгууллагад дүгнэлт хүргүүлж, COVID-19 цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор 1 /Улсын нөөц/ байгууллагад дүгнэлт гаргаагүй болно. Үүнд: “Зөрчилгүй” 30, Онцгой байдлын ерөнхий газрын аппаратын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн байна.

Онцгой байдлын ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 78,174.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 75,176.1 сая төгрөгийн алдааг залруулж, 77.3 сая төгрөгийн зөрчилд 13 төлбөрийн акт тогтоож, 757.0 сая төгрөгийн зөрчилд 31 албан шаардлага, 2,164.2 сая төгрөгийн алдаа, зөрчилд 61 зөвлөмж өглөө.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд 103.1 сая төгрөгөөр бараа материалыг илүү, үндсэн хөрөнгийг дутуу нэгтгэсэн;
- Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд 64,755.0 сая төгрөгөөр үйл ажиллагааны орлого илүү, 10,815.2 сая төгрөгөөр үйл ажиллагааны зардлыг илүү, 53,942.9 сая төгрөгөөр үйл ажиллагааны бус зардлын дүнг тус тус илүү нэгтгэсэн;
- Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд 9,052.9 сая төгрөгөөр үйл ажиллагааны мөнгөн орлого, нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 7,666.5 сая төгрөгөөр, үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээг 1,386.4 сая төгрөгөөр тус тус илүү нэгтгэсэн;
- Нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайланд нягтлан бодох бүртгэлтийн бодлогын өөрчлөлтийг 103.0 сая төгрөгөөр, үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралтыг 249.0 сая төгрөгөөр тус тус дутуу нэгтгэсэн;
- Төсвийн төвлөрүүлэн захирагч болон харьяа байгууллага хооронд үүссэн давхардсан ажил үйлчилгээний устгах бичилтийг санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд 64,755.0 сая төгрөгөөр, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд 9,052.9 сая төгрөгөөр дутуу тайлагнасныг санхүүгийн тайланд залрууллаа.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар нийт 253.5 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 49.5 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 204.0 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага өглөө. Үүнд:

1. Үндэсний аврах бригадын 8 суудлын автомашиныг ОБЕГ-ын бүтцийн нэгжийн газрын дарга нар албан ажлын хэрэгцээнд ашигласнаар 2020 оны байдлаар жолооч нарын цалин болон шатахууны зардалд нийт 84.3 сая төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь "Суудлын автомашины ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолтой нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

2. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу тайлант хугацаанд нийт байгууллагууд оруулбал зохих 6557 мэдээллээс хугацаа хоцроосон 742 мэдээлэл, 246 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3-т "Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан хүлээнэ" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

3. Тайлант онд барьцаа хөрөнгийн данснаас Булган шонхор ХХК-нд 42.7 сая төгрөгийг засварын зардалд, Эбоги ХХК-нд 77.0 сая төгрөгийг Улсын нөөцийн салбар цэгүүдэд өвс худалдан авахад тус тус засварын зардалд шилжүүлж зориулалт бусаар зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

4. Тайлант хугацаанд техник хяналтын зардлаас хэмнэгдсэн 49.5 сая төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-т "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.2-д "төсөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжүүлээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 2,164.2 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Нягтлан бодогч нарын ажлын ачаалал жигд бус, ажлын хариуцлага сул, хариуцсан ажлаа бүрэн гүйцэтгэж чадахгүй байгаа зэрэг байдал нь аудитыг гүйцэтгэхэд цаг хугацаа их шаардагдах, хүндрэл бэрхшээлтэй байв.

Онцгой байдлын ерөнхий газрын Улсын нөөцийн 2020 оны хугацаа хэтэрсэн нийт 3,272.0 сая төгрөгийн авлагын 66.5 хувь буюу 2,177.3 сая төгрөг нь хуулийн байгууллагаар шийдвэрлэгдэж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд байгаа ба үлдсэн 1,094.7 сая төгрөгийн авлага нь Тариалан эрхлэлтийг дэмжих сан /хуучнаар/-тай байгуулсан гэрээгээр аж ахуйн нэгжүүдээс авах авлагууд байна.

Дээрх авлага нь байгалийн гамшиг, гангийн нөхцөл байдлаас шалтгаалан тариалан эрхлэгчид ургац ардсанаас үүссэн бөгөөд авлагыг барагдуулах талаар нэгдсэн зохион байгуулалттай арга хэмжээ авах шаардлагатай байна.

Ковид-19 цар тахлын улмаас бүх нийтийн бэлэн байдал зарласантай холбоотойгоор ажлын тусгай горимоор ажилласан нь аудитыг гүйцэтгэх үе шатанд анхан шатны баримтуудыг хамруулах, тайлбар тодруулга авах, нотлох баримтуудыг бүрдүүлэх зэрэг горим, сорилыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн аудитаар анхаарах нь зүйтэй.

Ковид-19 цар тахалтай холбоотой хандив, тусламж, түүний зарцуулалтыг Шадар сайдын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын тайланд нэгтгэн оруулна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Онцгой байдлын ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 78,174.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 75,176.1 сая төгрөгийн алдааг залруулж, 77.3 сая төгрөгийн зөрчилд 13 төлбөрийн акт тогтоож, 757.0 сая төгрөгийн зөрчилд 31 албан шаардлага, 2,164.2 сая төгрөгийн алдаа, зөрчилд 61 зөвлөмж өгөв.

Дээрх алдаа, зөрчил илэрсэн нь дотоод хяналт, шалгалт аюулгүй байдлын газар харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт үр нөлөөгүй байна.

1.2. Эрсдэл:

Дотоод хяналт сул байгаагаас санхүүгийн сахилга бат суларч, төсвийн хөрөнгийг үрэлгэн зарцуулах.

1.3. Өгсөн зөвлөмж:

Дотоод аудитын албанаас харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийх, аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг барагдуулах нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	ОБЕГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			САГ-2021/03/СТА-ТТ3
Шалгагдсан байгууллагын нэр:	Онцгой байдлын ерөнхий газар		сая төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Үндэсний аврах бригадын 8 суудлын автомашиныг ОБЕГ-ын бүтцийн нэгжийн газрын дарга нар албан ажлын хэрэгцээнд ашигласнаар 2020 оны байдлаар жолооч нарын цалин болон шатахууны зардалд нийт 84.3 сая төгрөгийг зарцуулсан байна.	84.3	Албан шаардлага	Үндэсний аврах бригадын захирагч Санхүүгийн албаны дарга	Д.Намсрай А.Түвшинбаатар
2	Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу тайлант хугацаанд нийт байгууллагууд оруулбал зохих 6557 мэдээллээс хугацаандаа оруулсан 5500 мэдээлэл, хугацаа болоогүй 69, хугацаа хоцроосон 742 мэдээлэл, 246 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.	0.0	Албан шаардлага	Санхүү, хангалт, хөрөнгө оруулалтын газрын дарга Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч	Я.Гантөмөр Г.Бат-Эрдэнэ
3	Тайлант онд барьцаа хөрөнгийн данснаас Булган шонхор ХХК-нд 42.7 сая төгрөгийг засварын зардалд, Эбоги ХХК-нд 77.0 сая төгрөгийг Улсын нөөцийн салбар цэгүүдэд өвс худалдан авахад тус тус засварын зардалд шилжүүлж зориулалт бусаар зарцуулсан байна.	119.7	Албан шаардлага	Санхүү, хангалт, хөрөнгө оруулалтын газрын дарга Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч	Я.Гантөмөр Г.Бат-Эрдэнэ
4	Тайлант хугацаанд техник хяналтын зардлаас хэмнэгдсэн 49.5 сая төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.	49.5	Акт	Санхүү, хангалт, хөрөнгө оруулалтын газрын дарга Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч	Я.Гантөмөр Г.Бат-Эрдэнэ
5	Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2,998.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн нь дотоод хяналт, шалгалт аюулгүй байдлын газар харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт үр нөлөөгүй байна.	2,998.5	Зөвлөмж	Хяналт шинжилгээ, үнэлгээ, аюулгүй байдлын хэлтсийн дарга Ахлах мэргэжилтэн	Б.Батболд Б.Нямдорж
ДҮН		2,998.5			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2021 оны 03 дугаар сарын 25

№ 106/А0160059

Улаанбаатар хот

САГ-2021/03/СТА-773

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Онцгой байдлын ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд техник хяналтын зардлаас хэмнэгдсэн 49.5 сая төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-т "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.2-д "төсөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжүүлээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл" гэж заасныг зөрчсөн байна. Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Тайлант хугацаанд техник хяналтын зардлаас хэмнэгдсэн 49,534,185.00 /дөчин есөн сая таван зуун гучин дөрөв нэг зууг наян таван/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын хяналт шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, бригадын генерал Г.Ариунбуян, Санхүү, хангалт, хөрөнгө оруулалтын газрын дарга Я.Гантөмөр, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч Г.Бат-Эрдэнэ нарт даалгав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

Я.САМБУУНЯМ

Р.ЦОЛМОН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 25

№ 484/А0160059

Улаанбаатар хот

С.ӨГ - 2021/03/СТА - ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Онцгой байдлын ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үндэсний аврах бригадын 8 суудлын автомашиныг ОБЕГ-ын бүтцийн нэгжийн газрын дарга нар албан ажлын хэрэгцээнд ашигласнаар 2020 оны байдлаар жолооч нарын цалин болон шатахууны зардалд нийт 84.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Албан тушаалын болон албан ажлын суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтны жагсаалт"-ыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1. Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Албан тушаалын болон албан ажлын суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтны жагсаалт"-ыг хэрэгжүүлж, ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 1-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, бригадын генерал Г.Ариунбуян, Үндэсний аврах бригадын захирагч Д.Намсрай нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

Я.САМБУУНЯМ

Р.ЦОЛМОН



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban_Shaardlaga\2021\0325auditin 2-R Gazar80.Docx

001080929



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 25

№ 485/А0160059

Улаанбаатар хот

СМ-2021/10/СМ-ЗГТС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Онцгой байдлын ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд байгууллагын шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих 6557 мэдээллээс 742 мэдээллийг хугацаа хоцроож, 246 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх;”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;”, 7 дугаар зүйлийн 7.1.3-т “Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан хүлээнэ” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийн ил тод байдлыг ханган, тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай мэдээлэх, дээрх зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 1-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, бригадын генерал Г.Ариунбуян, Санхүү, хангалт, хөрөнгө оруулалтын газрын дарга Я.Гантөмөр, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч Г.Бат-Эрдэнэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

Я.САМБУУНЯМ

Р.ЦОЛМОН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2021\0325auditin 2-R Gazar78.Docx

001080921



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 25

№ 486/АД160059

Улаанбаатар хот

СНТ - 2021/03/СНТ - ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Онцгой байдлын ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:


Тайлант онд барьцаа хөрөнгийн данснаас Булган шонхор ХХК-нд 42.7 сая /Дөчин хоёр сая долоон зуун арван зургаан мянга есөн зуу/ төгрөгийг засварын зардалд, Эбоги ХХК-нд 77.0 сая /Далан зургаан сая есөн зуун ерэн нэгэн мянга/ төгрөгийг Улсын нөөцийн салбар цэгүүдэд өвс худалдан авахад тус тус засварын зардалд шилжүүлж зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "Санхүү төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16 дугаар зүйлийн 16.5.5-д заасан "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж, төсвийг зориулалтын дагуу зарцуулах, дээрх зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх талаар Онцгой байдлын ерөнхий газрын дарга, бригадын генерал Г.Ариунбуян, Санхүү, хангалт, хөрөнгө оруулалтын газрын дарга Я.Гантөмөр, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч Г.Бат-Эрдэнэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР



Я.САМБУУНЯМ
Р.ЦОЛМОН

[illegible]